

Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



Холбоо барих:

Майкл Ахэрн

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирагч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсүотэрхаусКүүпэрс Легал
ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

Монгол Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль нь 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001) хүчингүй болж улмаар төрийн эрх бүхий байгууллагуудаас баталсан олон төрлийн журмаар зохицуулагдаж байгаа бүх тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг нэгтгэж нэгдсэн нэг тогтолцоог бий болгох юм. Одоогийн байдлаар ойролцоогоор 914 тусгай болон бусад зөвшөөрөл байгаа нь Зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсноор 363 болж багасах ба бизнес эрхлэгчдийн дарамт ачааллыг бууруулах юм. Бид энэхүү мэдээллээрээ Зөвшөөрлийн тухай хуулийн онцлох өөрчлөлтүүд болон түүний бизнесүүдэд үзүүлэх нөлөөллийг товч байдлаар танилцуулж байна.



Хуулийн үйлчлэх хүрээ

Монгол Улсад хувь хүн, хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001)-д болон бусад хууль, дүрэм журамд тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх боломжтой. Зөвшөөрлийн тухай хуулийн гол зорилго нь бүх тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг нэг хуулиар зохицуулах бөгөөд аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөлд хуваан тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8 дугаар зүйлийн 8.2-т тус тус жагсаалт байдлаар оруулсан.

Зөвшөөрлийн тухай хууль нь тодорхой төрлийн харилцаанд үйлчлэхгүй. Эдгээрт газар өмчлөх эрх, виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой харилцаа, оюуны өмчийн эрхүүд, жагсаал цуглаан хийх, сүм хийд болон шашны байгууллага үүсгэн байгуулах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар үүсгэн байгуулах зэрэг орно.



Онцлох өөрчлөлтүүд

1. Зөвшөөрлийн ангилал

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зөвшөөрлийн зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог болон эрсдэлийн түвшнээс нь хамааруулан дараах ангилалд хуваасан. Үүнд:



Тусгай зөвшөөрөл

- Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа,
- тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа,
- ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулах үйл ажиллагаа



Энгийн зөвшөөрөл

- Нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа,
- тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа,
- байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулах бол

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсүотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсүотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.





Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



Онцлох өөрчлөлтүүд

• Тусгай зөвшөөрөл

Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар нь тусгай зөвшөөрлийг жагсаах байдлаар тусгасан. Ерөнхийдөө, энэхүү тусгай зөвшөөрлийн нарийвчилсан жагсаалтыг гаргахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд (2011) заасан үйл ажиллагаануудыг оруулснаас гадна тухайлсан хуулиар бий болгон зохицуулж байсан тусгай зөвшөөрлүүдийг мөн нэгтгэж өгсөн.

• Энгийн зөвшөөрөл

Тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл хоорондын гол ялгаа нь тухайн эрхлэх үйл ажиллагааны эрсдэл болон Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу байгалийн баялгийг ашиглаж байгаа эсэхээс шалтгаалж байна. Одоогийн байдлаар энгийн зөвшөөрөл нь өөр өөр хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулагдаж байгаа бөгөөд Зөвшөөрлийн тухай хууль нь энгийн зөвшөөрөлтэй эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны жагсаалтыг гаргаж өгснөөр бизнесүүд тухайн үйл ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхэд зөвшөөрөл шаардагдах эсэхийг шалгах боломжийг бий болгож байгаа юм.

2. Бизнесүүдэд үүсэж буй дарамтыг бууруулах

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тус хуульд нэмэлт өөрчлөлт орсноос бусад тохиолдолд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдүүд нь шинэ төрлийн тусгай эсхүл энгийн зөвшөөрлийг шинээр бий болгох, олгох нь хориотой. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар буюу шинээр зөвшөөрөл бий болгох дүгнэлт гаргаж, танилцуулна.



Зөвшөөрлийн тухай хууль нь зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан, шийдвэрлэлтийн явцыг хянах зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сантай байх шинэ зохицуулалтыг тусгажээ. Зөвшөөрөл авах өргөдлийг цахим хэлбэрээр гаргахаар хуульчилсан ч энэхүү цахим мэдүүлгийн талаар зөвшөөрөл олгох төрийн эрх бүхий этгээд нь нэгдсэн нэг системтэй байх уу эсхүл тус тусын цахим мэдүүлгийн системтэй байх уу гэдэг нь хуульд тодорхойгүй байгаа юм.

3. Зөвшөөрлийн хугацаа

Тухайлсан эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг зохицуулж буй хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 5 хүртэл жил, энгийн зөвшөөрлийг 3 хүртэл жилийн хугацаатай олгоно. Үүнээс үзвэл, одоо байгаа тусгай зөвшөөрлүүдийн хувьд тухайн салбарын хууль тогтоомжоороо зохицуулагдахаар байна. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрлийн анх олгосон хугацаагаар сунгана. Мөн, тус хуулиар татварын өргүй, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалсан зэрэг тодорхой нөхцөл шаардлагуудыг хангасан бол зөвшөөрлийн анх олгосон хугацааг хоёр дахин нэмэгдүүлж сунгах боломжтой байхаар шинэ зохицуулалт тусгажээ.

4. Тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл хүссэн өргөдөл болон сунгуулах хүсэлт шийдвэрлэх журам

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу, тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрлийг дараах журмаар шийдвэрлэнэ. Энэ нь:

	Баримт бичгийн бүрдлийг шалгах	Нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг магадлан шалгах	Магадлан шалгах ажиллагааны хугацааг сунгах	Шийдвэр гаргах
 Тусгай зөвшөөрөл	Ажлын 2 өдөр	Ажлын 10 өдөр	Ажлын 5 өдөр	Ажлын 5 өдөр
 Энгийн зөвшөөрөл	Ажлын 2 өдөр	Ажлын 5 өдөр	Ажлын 5 өдөр	Ажлын 5 өдөр



Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



Онцлох өөрчлөлтүүд

Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд зургаан сарын дотор дахин хүсэлт хүлээн авахгүй байхаар хуульчилсан тул бизнес эрхлэгчид тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа сайтар бэлтгэх шаардлагатай болсон байна. Зөвшөөрлийн тухай хуулиар эрх бүхий байгууллагуудад зөвшөөрөл эзэмшигчид зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө мэдэгдэх үүргийг хуульчилсан. Харин тусгай эсхүл энгийн зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана. Тусгай эсхүл энгийн зөвшөөрөл эсэхээс хамаарч хугацааг сунгуулах өргөдлийг ажлын 10-12 хоногийн дотор шийдвэрлэхээр байна. Хэрвээ эрх бүхий байгууллага нь хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрөл сунгуулах өргөдөлд хариу өгөөгүй бол зөвшөөрлийн анх олгосон хугацаагаар сунгасанд тооцно.

5. Тусгай болон энгийн зөвшөөрлийг хүчингүй болгох

Тусгай болон энгийн зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл нь бизнес эрхлэгчдийн хувьд анхаарах чухал зүйлсийн нэг байдаг. Зөвшөөрлийн тухай хуульд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001)-д заасан үндэслэл дээр нэмж хүчингүй болгох дараах шинэ үндэслэлүүдийг тусгасан байна. Эдгээр нь:

- зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол; болон
- зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн бол.

Ийнхүү хүчингүй болгосны үр дагавар нь тухайн зөвшөөрөл эзэмшигчээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно. Мөн түүнчлэн, зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нь зөвшөөрлийг хүчингүй болгосны улмаас бусад учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.



Та дээрх сэдэв болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол бидэнтэй холбоо барина уу.

Дараах линкээр орж дэлгэрэнгүй танилцана уу: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311>



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.